

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

2023-01-06

2022 онд иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тухай

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар, 17 сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 газар, хэлтэс, агентлаг, албан тушаалтанд 2022 оны эхний хагас жилд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг нэгтгэн танилцуулж байна.

2022 онд аймгийн хэмжээнд төрийн байгууллага, албан тушаалтанд нийт **3522** иргэн хандаж санал, хүсэлт, өргөдөл, гомдол гаргаснаас **3441** иргэний өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь **97.7** хувийн үзүүлэлттэй байна. Хугацаа болоогүй болон хугацаа сунгах шаардлагатай **81** өргөдөл, гомдол байна. Нийт ирсэн өргөдөл, гомдол нь 2021 онтой харьцуулахад 1949 буюу **35.6** хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Мөн **84** өргөдлийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдолд иргэдийн төрсний бүртгэл, регистрийн дугаарын зөрчил, цахим үнэмлэхээ сунгуулах, шилжилт хөдөлгөөн, бүртгэлийн хугацаа хэтэрсэн, халаалт дулаантай холбоотой болон бусад газрын харилцаа, нийгмийн халамжид хамрагдахыг хүссэн, хүүхдийн мөнгөний халамжид хамрагдах, мөнгөн тусламж, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн үйлчилгээний холбоотой асуудлаар тавьсан хүсэлт дийлэнх хувийг эзэлж байна.

Нэг. Иргэдээс аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт хандаж гаргасан өргөдөл гомдлын талаар:

2022 оны байдлаар иргэдээс аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт хандаж **179** өргөдөл, гомдол гаргасан байна. Хуулийн хугацаанд **179** шийдвэрлэсэн нь **100** хувийн үзүүлэлттэй байна. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хэлбэрээр нь авч үзвэл бичгээр **128**, аймгийн ЗДТГ-ын 7036-1111 утсанд **51** өргөдөл,

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

гомдол ирүүлсэн байна. Мөн Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төвд иргэдээс **273** санал хүсэлт, гомдол гаргаснаас гомдол **191**, хүсэлт **47**, санал **31**, талархал **4** тус тус ирсэн ба **273** шийдвэрлэсэн нь **100** хувийн шийдвэрлэлттэй байгаа бөгөөд энэ дүн тайланд тооцогдоогүй болно.

Ирүүлсэн өргөдөл, гомдлыг агуулга, зонхилж буй асуудлаар авч үзвэл санхүүгийн дэмжлэг, буцалтгүй тусламж хүссэн, ажилд орохыг хүссэн, хот тохижилтын талаар, газрын маргаантай холбоотой асуудлууд дийлэнх хувийг эзэлж байна. Хугацаа болоогүй, судалж байгаа **81** өргөдөл байгаа нь санхүүгийн дэмжлэг хүссэн, газрын маргаан болон эмчилгээний зардал хүссэн төсөв санхүүтэй холбоотой асуудлууд байна.

Хоёр. Иргэдээс сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт хандаж гаргасан өргөдөл, гомдлын талаар:

2022 онд иргэдээс сумдын Засаг дарга, түүний Тамгын газар, тосгодын Захирагч нарт хандаж **1825** өргөдөл, гомдол гаргасан байна. Үүнээс хуулийн хугацаанд **1765** шийдвэрлэсэн нь **96.7** хувийн үзүүлэлттэй байна. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хэлбэрээр нь авч үзвэл бичгээр 1530, цахимаар 67, утсаар 140, биечлэн уулзаж 80, бусад хэлбэрээр 8 ирүүлсэн байна. Ирүүлсэн өргөдөл, гомдлыг агуулга, зонхилж буй асуудлаар авч үзвэл санхүүгийн дэмжлэг, буцалтгүй тусламж хүссэн, ажилд орохыг хүссэн, газар тариалан, хадлангийн талбайн маргаан, газрын харилцаа, иргэний бүртгэл, нийгмийн халамжтай холбоотой асуудлууд дийлэнх хувийг эзэлж байна. Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн өргөдөл байхгүй байна.

Гурав. Иргэдээс газар, хэлтэс, алба, байгууллагуудад хандаж гаргасан өргөдөл гомдлын талаар:

2022 онд иргэдээс газар, хэлтэс, албад, байгууллагуудад хандаж **1498** өргөдөл, гомдол гаргасан байна. Үүнээс хуулийн хугацаанд **1477** шийдвэрлэсэн нь **98.5** хувийн үзүүлэлттэй байна. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хэлбэрээр нь авч үзвэл бичгээр 1390, цахимаар 35, утсаар 71, биечлэн 2 тус тус ирүүлсэн байна. Ирүүлсэн өргөдөл, гомдлыг агуулга, зонхилж буй асуудлаар авч үзвэл хүүхэд, гэрбүл, нийгмийн даатгал, газрын харилцаа, иргэний бүртгэл, нийгмийн халамжтай холбоотой асуудлууд дийлэнх хувийг эзэлж байна. Өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлээгүй.